

“МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО” ХК-ИЙН НОГДОЛ АШГИЙН ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн (цаашид “Компани” гэх) Ногдол ашгийн журам (цаашид “Журам” гэх) нь ногдол ашгийн бодлогын баримт бичиг бөгөөд хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэр гаргах, ногдол ашгийн хэмжээ, хуваарилах нөхцөл журмыг тодорхойлох, ногдол ашиг хуваарилах болон хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Энэхүү Журам нь Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”, Компанийн дүрэм болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн бөгөөд Компани ногдол ашиг хуваарилах, төлөх үйл ажиллагаанд хууль, дүрэм, журмуудыг мөрдлөг болгон ажиллана.

1.3. Энэхүү Журмыг Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалтад заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-өөс боловсруулан баталж, үйл ажиллагаандаа мөрдөнө.

1.4. Компанийн хувьцаа эзэмшигч болон ирээдүйн хөрөнгө оруулагчдад энэхүү Журам нь компанийн ногдол ашиг хуваарилалтын бодлого, хэмжээ, хуваарилах арга хэлбэрийн талаар тодорхой нэгдсэн ойлголтыг хүргэнэ.

ХОЁР. НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО


2.1. Компанийн ногдол ашгийн бодлого нь компанийн үйл ажиллагаа болон стратегийн бодлоготой уялдсан байна.

2.2. Компанийн хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчдын оруулсан хөрөнгийг зохистой захиран зарцуулж, жил бүр ногдол ашгийн хэмжээг зохистой түвшинд байлгах зорилготой ажиллана.

2.3. Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйл, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсэг, энэхүү журмын 3 дугаар зүйлд заасан ногдол ашиг хуваарилах нөхцөл хангагдсан тохиолдолд ногдол ашиг хуваарилна.

2.4. Нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээг тухайн санхүүгийн жилийн татвар төлсний дараах цэвэр ашгийн хэмжээ, компанийн богино болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага зэргийг үндэслэн ТУЗ тухай бүр тогтооно.

2.5. Компанийн жилийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас бизнес төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалт, нийгмийн арга хэмжээний



хуваарилалтыг хасаад үлдэх хэсгийг ногдол ашигт хуваарилах эсэхийг ТУЗ-ийн хурлаар шийдвэрлэнэ.

2.6. Тухайн санхүүгийн жилд олсон цэвэр ашиг нь өмнөх жилийнхээс буураагүй тохиолдолд ногдол ашгийн хэмжээг бууруулахгүй байх бодлого баримтална. Энэ нь Компанийн богино болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагаас хамаарч өөрчлөгдөж болно.

2.7. Ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр хуваарилах бөгөөд эд хөрөнгийн, эсхүл компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно.

ГУРАВ. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ НӨХЦӨЛ

3.1. Нэг төрлийн хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилна.

3.2. Компани нь доор дурдсан тохиолдолд энгийн хувьцаанд ногдол ашиг хуваарилна. Үүнд:

3.2.1. Ногдол ашиг төлсний дараа компани нь төлбөрийн чадвартай байх;

3.2.2. Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, түүний татан буулгалтын үнэ, компанийн дүрэмд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ зэргийн нийлбэрээс их байх;

3.2.3. Компани нь эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх.

3.3. Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь 25 хувиас дээш хувиар багассан тохиолдолд компани нь ногдол ашгийг шилжүүлсэн өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор зээлдүүлэгчид өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр мэдэгдэнэ.

ДӨРӨВ. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ЭСЭХ ШИЙДВЭР

4.1. Компанийн ТУЗ нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

4.2. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрт дараах зүйлсийг тусгасан байна. Үүнд:

4.2.1. хувьцааны төрөл тус бүрээр нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ;

4.2.2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр;

4.2.3. Ногдол ашиг төлөх өдөр буюу олгож эхлэх, дуусах хугацаа;

4.2.4. Ногдол ашгийг олгох хэлбэр.

4.3. Компани нь тухайн санхүүгийн жилд ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн бол энэ тухайгаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд заавал тайлагнах бөгөөд тайлбартаа ногдол ашиг хуваарилах боломжгүй байгаа үндэслэл

шалтгаан, санхүүгийн тооцоолол, цаашид ногдол ашиг хуваарилах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тайлбар зэргийг тусгасан байна.



ТАВ. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ, МЭДЭЭЛЭХ, ТАЙЛАГНАХ

5.1. Ногдол ашиг хуваарилах хэлбэр, олгох хугацаа, журам нь хувьцаа эзэмшигчдэд аль болох тохиромжтой байна.

5.2. Ногдол ашгийг ТУЗ-өөс тогтоосон хугацаанд “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн дансанд шилжүүлээгүй бол хувьцаа эзэмшигчийн нэхэмжлэлээр алданги төлнө.

5.3. Тогтоосон хугацаанд ногдол ашгаа аваагүй нь тухай хувьцаа эзэмшигчийн ногдол ашиг авах эрхийг үгүйсгэх, эсхүл компани ногдол ашиг олгохгүй байх үндэслэл болохгүй.

5.4. Компани ногдол ашиг хуваарилахтай холбоотой мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон компанийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргэх бөгөөд үүнийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хариуцан зохион байгуулна.

5.5. Ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр гарсан үед төлбөл зохих Ногдол ашгийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны хадгаламжийн дансанд шилжүүлэх бөгөөд Нягтлан бодох бүртгэл хариуцсан нэгж хариуцан зохион байгуулна.

5.6. Нягтлан бодох бүртгэл хариуцсан нэгж нь ногдол ашиг хуваарилалтын тайланг Төлөөлөн удирдах зөвлөл, Санхүүгийн зохицуулах хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнах асуудлыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хариуцна.

ооОоо